


**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ БАНЗАРДАРЬ ОВОГТОЙ ЭРДЭНЭХҮҮГИЙН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Сонгуулийн уриа: Эрдэнэтийн хөгжил иргэдээсээ эхэлнэ.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг 2 хэсэгт багтаан томъёолж өгсөн болно.

Зорилт 1. Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

- 1.1. Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай уялдуулан Хотын соёлыг түгээх, шинэ цаг үеийн хотын иргэд, хотын залуус байх аливаа уриалтыг нийгэмд түгээж ажиллана.
- 1.2. Соёл урлагын салбарт бодлогын шинэчлэлийг хийж нийгмийн асуудлалд шийдвэрлэхэд анхаарч ажиллана.
- 1.3. Хүүхэд залуучуудад чиглэсэн соёл урлагийн боловсрол олгох цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж, дэлхийд үнэлэгдэхүйц Монгол иргэнийг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.4. Соёлын салбарт ажиллагдын мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэн, мэргэжлийн ажилтнаар ханган, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 1.5. Соёлын байгууллагад шаардлагатай хөгжмийн зэмсэг, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ
- 1.6. Залуучуудын байгууллагын санаачлагыг дэмжих, залуучуудын авьяас сонирхолыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулсан төрөл бүрийн клуб байгуулах санал санаачлагыг дэмжинэ.
- 1.7. Залуу гэр бүл, өрх толгойлсон олон хүүхэдтэй эхчүүд, эрүүл мэнд, соёл урлаг, боловсрол, цагдаа хучний байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх тал дээр анхаарч ажиллана.
- 1.8. Эрдэнэт хотын иргэд байгалийн баялагтаа эзэн байх, үр шимийг нь хүртдэг байх талаар Эрдэнэт хотоос УИХ-д сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.
- 1.9. Ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах, ажлын байр олноор бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.10. Иргэдийн амьжиргааг дэмжих, бага орлоготой иргэдэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж өөрсдийнх нь оролцоог хангаж хэрэгжүүлнэ.
- 1.11. Ажлын байр нэмэгдүүлэх гол эх үүсвэр нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг олноор бий болгохтой холбогдох ба энэ чиглэлд ЖДУсан болон бусад дэмжлэгийн сангуудын үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй байхад анхаарч дэмжиж ажиллана.
- 1.12. Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас зэрэг иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмнэлэгүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, зайлшгүй техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлэгийн ажилтнуудыг давтан сургах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэд саадгүй түргэн шуурхай авч байх тал дээр анхаарч ажиллана.



Б. Ч/Ч

- 1.13. Гэр хороололд амьдарч буй иргэдэд агаар хөрсний бохирдлыг арилгах тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр УИХ, ЗГ, холбогдох яамд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж эхлүүлнэ. Хогны менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.
- 1.14. Эрүүл зөв хэрэглээг дэмжих зорилгоор хотын төв болон бусад хэсэгт дугуйн замтай болох ажлыг эхлүүлж мэргэжлийн байгууллагаар зураг төсөл, холбогдох судалгааг хийлгэж, эхлүүлнэ.
- 1.15. Нийтийн тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулж, тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарна.
- 1.16. Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд үйл ажиллагаа явуулж буй клубүүд, спортын холбоодын зохион байгуулалтыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.17. Эрдэнэт хот Эрдэнэт үйлдвэрийг барьж байгуулсан Илгээлтийн эзэд, Анхдагчид руу хандсан бодлогыг шинэчлэн хэрэгжүүлнэ.
- 1.18. Ахмад, Эмэгтэйчүүд, Залуучууд, Хүүхдүүд рүү хандсан нийгмийн хайлцааг зохицуулах, дэмжсэн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ. Өндөр настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү хандсан нийгмийн дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх тал дээр онцгойлон анхаарч ажиллана.
- 1.19. Орон нутгийн дотоод зах зээлээ хамгаалах, хүнс, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдалд онцгой анхаарч эрх зүйн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.20. Эрдэнэт хотыг үер усны болзошгүй аюулаас хамгаалах үерийн хамгаалалтын далан барих асуудалд онцгой анхаарч дэмжиж ажиллана.
- 1.21. Хотын иргэдийн аюулгүй байдалд анхаарч камержуулалтын системийг төгөлдөржүүлэх, хууль сахиулах онцгой чиг үүрэг бүхий байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгслээр дэмжиж, бэлэн байдлыг хангуулахад хамтран ажиллана.


Зорилт 2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

- 2.1. Орон сууцнуудын хуучирч муудсан инженерийн шугам сүлжээг үе шаттай засварлах, солих.
- 2.2. Орон сууцны байрны гаднах хүүхдийн тоглоомын талбайн ашиглалтыг сайжруулах, засаж янзлах, үе шаттай нэмэгдүүлэхэд анхаарна.
- 2.3. Байр хоорондын авто замын нэвтрүүлэх чадавхийг нэмэгдүүлж, өргөтгөх, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, явган замыг сайжруулах, үерийн ус зайлзуулах шугмын ажлыг хийх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.4. Багийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг багийн ЗД-ын ажлын алба, Цагдаагийн хэсэг, Өрхийн эмнэлэгийн ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэдэг зохицуулалтыг бий болгоно.
- 2.5. Багийн хэмжээнд ахмад настны хөгжлийн төв, залуусын чөлөөт цагийн төв, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх төв, эцэг эхчүүд гэр бүлд зориулсан төв байгуулах зэрэг аливаа үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.
- 2.6. Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж бодлогоор дэмжинэ.
- 2.7. Багийн харьялал бүхий ажил хөдөлмөр идэвхитэй хайж байгаа иргэдэд туслах зорилго бүхий Хөдөлмөрийн бирж ажиллуулах бодлого зохицуулалт хийнэ.



О. Нямжаргалан

- 2.8. Багийн нутаг дэвсгэрт буй ногоон байгууламжийг арчилж тордох, цаашид үе шаттай нэмэгдуулж, багийн иргэд өөрсдөө оролцож тарьж ургуулдаг боложийг нээж өгнө.
- 2.9. Ахмад настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандуулах нийгмийн бүхий л дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх ажилд онцгой анхаарна.
- 2.10. Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай холбогдуулан багийн хэмжээнд хотын соёлыг түгээх, соён гэгээрүүлэх ажлуудыг иргэдийн шууд оролцоотойгоор өргөн хүрээнд зохион байгуулна.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан.  Б.Эрдэнэхүү

2020.07.23

